



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/Н

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуул ах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ын хэрэгжүүлэх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл 31 хоногийн хугацаанд дархлаажуулалтын цэгт 2 ажилтан, аймгийн "Шуурхай штаб"-т үүрэг гүйцэтгэж буй жижүүрийн 4 алба хаагчдын хоолны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 3,120,000 (гурван сая нэг зуун хорин мянган) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010000

Аймгийн Засаг даргын 2022 оны
..... дүгээр сарын өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

д/д	Байгууллага нэр	Зардлын нэр төрөл		
		Хоолны зардал /шуурхай штаб/ 31 хоног 4 хүн	Дархлаажуулалтын цэг хоолны зардал /31 хоног 2 хүн/	Дүн
1	Аймгийн Онцгой комисс	2,480,000	640,000	3,120,000
	Дүн	2,480,000	640,000	3,120,000